



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

「Үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож,
балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 14,100,000.00 (арван дөрвөн сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0130 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001442
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
10.0 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ХИЛ
ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН
0130 ДУГААР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ (автомашин)

Д/д	Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглал тад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил (жилээр)
1	Тоёота приус-20, 06-22 ХОУ (арал-nhw207776243)	2018	14,100,000.00	6,000,000.00	5
	Нийт дүн		14,100,000.00 (арван дөрвөн сая нэг зуун мянга)	6,000,000.00 (зургаан сая)	